

Журам

Бүлэг бүр Ээжүүд Хамтдаа Залбирах нь Олон Улсын Байгууллагын журмыг дагах үүрэгтэй. Эдгээр нь сонголтот журам биш болно.

1. Ээжүүд Хамтдаа Залбирах нь Олон Улсын Байгууллагын Итгэлийн Тунхаг болоод Журмыг дагаагүй аливаа хувь хүн эсвэл бүлэг нь Ээжүүд Хамтдаа Залбирах нь байгууллагын нэр, логог ашиглах эрхгүй бөгөөд тус үйлчлэлийг ямар нэгэн байдлаар төлөөлөхгүй.
2. Ээжүүд Хамтдаа Залбирах нь Олон Улсын Байгууллага бол ямар нэгэн улс төрийн чанартай ухуулан ятгах бүлэг биш юм. Энэхүү үйлчлэлээс гадуурх улс төр, нийгмийн оролцоо нь хувь хүний зөвхөн өөрийнх нь асуудал байх болно. Ямар ч тохиолдолд Ээжүүд Хамтдаа Залбирах нь байгууллагын нэрийг өөр бусад асуудалтай холбоотойгоор ашиглахыг хориглоно.
3. Хувь хүний нууцыг хадгалах нь шударга байдлыг үйлчлэлд авчирдаг учраас бүх залбирлын хүсэлт бүлэг дотроо хадгалагдах ёстой.
4. Ээжүүд Хамтдаа Залбирах нь бүлгүүд уулзалтаа сургуулийн байранд хийж болохгүй. Бид сургуулийн төлөө залбирдаг болохоос сургууль дээр залбирдаггүй.
5. Ээжүүд Хамтдаа Залбирах нь бүлэг нь залбирлын хүсэлт өгөх хүсэлгүй хүмүүсээс гуйж авах эсвэл, залбирлын хүсэлтийн хайрцаг улсын сургуульд байршуулахыг хориглоно.
6. Ээжүүд Хамтдаа Залбирах нь бүлэг нь гишүүн элсүүлэх зорилгоор сургуулиудыг ашиглаж болохгүй.
7. Ээжүүд Хамтдаа Залбирах нь байгууллагын нэр болон логог зөвшөөрлөлгүйгээр ашиглахыг хориглоно. Энэ бол Ээжүүд Хамтдаа Залбирах нь Олон Улсын Байгууллагын лого учир үүнийг ашиглахын тулд заавал бичгээр зөвшөөрөл авсан байх шаардлагатай.
8. Ээжүүд Хамтдаа Залбирах нь бүлгийн ажил үүргийн хуваарь нь зөвхөн энэ үйлчлэлд хамаатай. Уг ажлын хуваарийг ямар ч тохиолдолд хөндлөнгийн хувь хүн, байгууллага, бизнес, өөр гадны бүлэг ашиглах эсвэл эдгээр этгээдүүдэд задруулах, өгөх, зээлдүүлэхийг хориглоно.
9. Сурталчилгааны ямар нэг мэдээллийг Ээжүүд Хамтдаа Залбирах нь Олон Улсын Байгууллагын бүх төрлийн материал дээр байрлуулахыг хориглоно.
10. Ээжүүд Хамтдаа Залбирах нь бүлгийн уулзалтын үеэр Залбирлын Дөрвөн Алхамыг ашиглан санаа нэгдэн (нэг сэдвээр) харилцан яриа хэлбэрээр залбирдаг. Тиймээс энэ үеэр залбирлын хүлээн зөвшөөрөгдсөн хэлбэр хэдий ч чангаар харь хэлээр ярихгүй байхыг хүсье. Мөн түүнчлэн библийн дагуу бус бясалгал маягийн залбирал, залбирлын лабиринт ашиглах, амьсгалын залбирал (нэг үгийг дахин дахин давтах), төвлөрөх залбирал (маани унших мэт) энэ бүлэгт хийхгүй.
11. Ээжүүд Хамтдаа Залбирах нь бүлэг нь аливаа хов жив, шүүмжлэлийн чанартай ярианд оролцож болохгүй.
12. Ээжүүд Хамтдаа Залбирах нь бүлэг нь зөвхөн эмэгтэйчүүдэд зориулсан бүлэг юм.